

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**

*Академич А.Лувсандэндэвийн
мэндэлсний 80 насны ойд зориулав.*

**ТОЛЬ БИЧИГ СУДЛАЛЫН
АСУУДАЛД**

Эмхтгэн, эхийг бэлтгэсэн: Д.ТҮВШИНДЭЛГЭР

Редактор: С.МӨНХСАЙХАН (Ph.D)

**Улаанбаатар хот
2008 он**

ГАРЧИГ

Л.БОЛД	Академич А.Лувсандэндэв бол нэрт толь зүйч мөн	5-18
Ц.ШАГДАРСҮРЭН	Монгол толь бичгийн судлал	19-68
Л.БОЛД	Монгол хэлний тайлбар толийн уламжлал, шинэчлэлийн асуудалд.....	69-93
Г.ЦЭЦЭГДАРЬ	Араб үсгээр тэмдэглэсэн дундад үеийн монгол хэлний толиуд.....	94-112
Б.ТҮВШИНТӨГС	Монгол, манж хоёр хэлний толийн тухай.....	113-133
Ц.БАТДОРЖ	“Чихний чимэг” хэмээх нэр томъёоны толь бичиг.....	134-149
Ш.ЧОЙМАА	С.Шагжийн “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”-ийн үндсэн онцлог, баримталсан зарчим.....	150-161
Л.БОЛД	Я.Цэвэлийн тайлбар толийн тухай.....	162-178
С.МӨНХСАЙХАН	Хятад монгол, монгол хятад орчуулгын толийн уламжлал, өнөөгийн байдал.....	179-210
Д.БҮРНЭЭ	A review of the tibetan-mongolian lexicographical tradition.....	211-217
Л.БОЛД	“Монгол хэлний зөв бичих зүйн толь” зохиох тухай асуудалд.....	218-234
ТОВЧИЛСОН ҮГ	235

CONTENT

L.BOLD	<i>Academician A.Luvsandendeв is a famous lexicographer</i> 5-18
TS.SHAGDARSUREN	<i>Mongolian lexicology</i> 19-68
L.BOLD	<i>The explanation dictionary of Mongolian (tradition and innovation)</i> .69-93
G.TSETSEGDARI	<i>Mongolian dictionaries of middle ages by Arabic letter</i> 94-112
B.TUVSHINTUGS	<i>About Mongolian and Manchu lexicography</i>113-133
TS.BATDORJ	<i>About a terminological dictionary - "Chikhonii chimeg"</i> 134-149
SH.CHOIMAA	<i>The main peculiarity and basic principle of Shagi's "Orthographical dictionary of Mongolian letter's"</i> 150-161
L.BOLD	<i>About an explanation dictionary of Ya.Tsevel</i> 162-178
S.MUNKHSAIKHAN	<i>Tradition and recent notice "Chinese-Mongolian, Mongolian-Chinese dictionaries"</i> 179-210
D.BURNEE	<i>A review of the Tibetan-Mongolian lexicographical tradition</i> 211-217
L.BOLD	<i>The problem to create "Mongolian orthographical dictionary"</i> 218-234

Г.ЦЭЦЭГДАРЬ

*МУБИС-ийн МСС-ийн багш
доктор (Ph.D), дэд профессор*

АРАБ ҮСГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ТОЛИУД

XIII-XIV зууны үед хүчирхэг нэгдсэн гүрнийг байгуулсан монголчуудын хэл, соёл нь зөвхөн айл зэргэлдээ улс үндэстнүүд төдийгүй Евро Азийн соёл иргэншил бүхий улс үндэстнүүдэд ч үлэмжхэн нөлөөлжээ. Түүний нэгэн гэрч нь дундад зууны перс зүгийн эрдэмтэн мэргэд монгол хэлийг сурч судлан, монгол хэлний үгсийг өөрийн үсгээр тэмдэглэх арга зарчмыг боловсруулж, улмаар араб монгол, перс монгол зэрэг хоёр хэлний толиудаас гадна араб перс түрэг монгол дөрвөн хэлний толь, тэр ч байтугай араб перс түрэг грек армян монгол зэрэг зургаан хэлний толь бичгийг ч эмхтгэн гаргасан байна. Энэ бүхнээс үндэслэн XIV-XV зууны монгол хэл нь Ойр дорнод болон Газар дундын тэнгисийн эргийг тойрсон эртний соёлт Грек, Египет, Түрэг болон Персүүдийн хэлтэй нэгэн зиндаанд хэрэглэгдэж байсныг дашрамд дурдах нь зүйтэй.

Араб үсгийн монгол дурсгалуудын хэл нь XIII-XIV зууны монголын их гүрэнд багтаж байсан олон аялгуутны дотроос өрнөд аялгууны шинжийг тусгасан байж болно гэж зарим эрдэмтэд үздэг билээ. Гэвч ийм саналыг бүрэн хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Учир нь, араб үсгийн монгол дурсгалууд нь тэр үеийн баруун монголын хэл аялгууг судалсан бүтээл бус, харин Перс газар очсон монголчуудын хэл аялгуун дээр тулгуурлан тэндэхийн эрдэмтэн мэргэдийн бичиж тэмдэглэсэн зүйл гэж үзэх нь үнэнд илүү ойртоно. Хэрэв тийм бол тэр үеийн Перс, одоогийн Иранд хүрч очсон монголчууд нь заавал баруун монголоос гаралтай байх албагүй, харин ч хааны ордныхны шадар хүмүүс буюу дорнод монголын гаралтай хүмүүс байх илүү магадлалтай билээ. Араб үсгийн монгол дурсгалууд нь монгол хэлний чухам аль аялгууны онцлогийг тусгасан болохыг тогтоох нь төдий л гол бус, харин монгол хэлний хөгжлийн чухам аль үеийн онцлог шинжийг тусгаж байгааг түүхэн үүднээс судлах нь илүү чухал ач холбогдолтой билээ.

Монгол хэлийг оролцуулсан тэдгээр толь бичгүүдийг персийн эрдэмтэн Ибн ал-Муханн, Имад ал-Карахисари, Хамдуллаха Казвин, Расулидын ван Ал Аббас Али нарын зэрэг тэр цагийн нэрт эрдэмтэд зохиожээ. Тэд дорно дахины ард түмний толь бичиг зохиох уламжлалт аргад тулгуурлан зүйл хуваасан толиуд туурвисан байна.

Араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний толиудыг судлах ажил XX зууны эхнээс эхэлсэн бөгөөд тэр үеэс оросын эрдэмтэн П.М.Мелиоранский, Н.Поппе, францын эрдэмтэн П.Пеллио, унгарын эрдэмтэн Л.Лигети, Г.Кара, германы эрдэмтэн М.Вайерс, японы эрдэмтэн Ш.Ивамура, Ё.Сайто, монголын эрдэмтэн Д.Төмөртоого, Г.Цэцэгдарь нарын хийсэн үсэг зүй, авиа зүй, хэл зүй, толь зүйн судалгааны бүтээлүүд гарчээ.

Энд бид юуны өмнө эдүгээ бидний үед уламжлан үлдсэн араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний толиуд болон тэдгээрийн судалгааны талаар товч дурдъя.

“Мукаддимат ал-Адаб толь”-ийн монгол хадмал орчуулга

XII зууны үеийн Хорезмийн нэрт эрдэмтэн Абул-Касим Махмуд бин Омар ал-Замахшари (1075-1144)-ийн зохиосон “Мукаддимат ал-Адаб” хэмээх араб перс толийн хоёр өөр хувилбарыг 1926 онд Ибн-Синий нэрэмжит Бухар хотын номын сангаас олжээ. Тэрхүү хоёр өөр хувилбарын эхнийх нь 1305 онд Хамид Хафиз гэдэг хүний хуулбарласан араб перс толь, нөгөө нь 1492 онд Дервиш Мухаммед гэдэг хүний дахин хуулбарласан араб перс түрэг монгол дөрвөн хэлний толь байжээ. Замахшари Хорезмын хааны номын санд зориулан араб перс толийг анх зохиосон бөгөөд хожмын эрдэмтэд түүний ард турк, монгол хадмал орчуулгыг нэмэн оруулсаар XIV зууны үе болж ирэхэд уг толь нь дөрвөн хэлний толь болсон байна. Уг толийн доторх турк хадмал орчуулгыг Замахшари хожим өөрөө нэмж хийсэн байж ч магадгүй гэсэн саналыг профессор Н.Поппе дэвшүүлсэн байна. Монгол хадмал орчуулгыг нь чухам хэн хэдийд хийсэн тухай тодорхой мэдээ тэмдэглэгдэн үлдсэнгүй. Уг толийн хуулсан цаг хугацаа нь хэдийгээр 1492 онд хамаарах боловч түүнийг анх бичсэн цаг үе нь түүнээс нэлээд өмнөх үед хамаарна гэж профессор Н.Поппе тэмдэглэсэн бол Өвөр Монголын эрдэмтэн Шонхор түүнийг бүр “Хуа-й й-юү толь”-оос хойш буюу XV зууны үед бичигдсэн гэж үзсэн байна.

“Мукаддимат ал-Адаб” толийн монгол хадмал орчуулга нь бүгд 3500 орчим толгой үгтэй бөгөөд дотроо холбоо үг, хэлц хэллэг, хураангуй өгүүлбэрийн олон сонирхолтой жишээг багтаажээ. Энэхүү дурсгал нь үгийн тоо хэмжээгээрээ, эдүгээ бидний үед уламжлан үлдсэн араб үсгийн монгол дурсгалуудын дотроос хамгийн том нь төдийгүй авиа зүй, хэл зүй, үгсийн сангийн шинжээрээ хамгийн баялаг дурсгал юм. Профессор Н.Поппе Бухарын номын санд хадгалагдаж байсан энэхүү дурсгалын гэрэл зургийн эх дээр тулгуурлан анхны томоохон судалгаагаа хийжээ.¹

¹Н.Поппе — “Монгольский словарь Мукаддимат ал-Адаб”, /ТИВ 14/, т. I-II, М.-Л., 1938, 3-393

Тэрбээр уулаас зүйл хуваасан зохиомжтой байсан уг толийн бүх үгсийг латин үсгийн дараалалд оруулан толгойлж, үг тус бүрийг латин галигаар буулгаж, араб бичлэг, орос орчуулга дагалдуулсан нь түүнийг уншиж судлахад нэн дөхөмтэй болжээ. Мөн энд уул дурсгалын авиа зүй, хэл зүйн онцлог шинжүүдийг тодорхой жишээн дээр тулгуурлан гаргасан нь зөвхөн араб үсгийн монгол дурсгал төдийгүй дундад үеийн монгол хэлний судлалд чухал хувь нэмэр болсон билээ. Саяхан Японы эрдэмтэн Ё.Сайто энэхүү толийн бүх үгсийг шинэчлэн галиглаж, үгсийн давтамжийг компьютероор тооцоолон гаргасан бөгөөд энэ нь тухайн дурсгалыг анх удаа үсгийн галигаар буулгасан судалгаа болов.²

“Ибн-Муханны толь”-д орсон монгол үгс.

XIV зууны эхэн үеэр баруун хойд Перст Ибн ал-Муханн (*Camalu ʿ-din ibn-u ʿ-Muhanna*) хэмээх перс эрдэмтний зохиосон перс монгол толь нь хэл шинжлэлд “Ибн-Муханны толь” хэмээн алдаршсан билээ. Эдүгээ энэхүү толийн гурван өөр хувилбар уламжлан үлдсэн байна.³

Хамгийн анх Оросын эрдэмтэн П.М.Мелиоранский уг толийн нэгэн хувилбарыг олж судалсан бөгөөд хожим Истанбулд дахин хэвлэгдсэн өөр нэгэн хувилбарыг профессор Н.Поппе, гуравдахь хувилбарыг М.Вайерс нар олж судалсан байна. Дээр дурдсан гурван хувилбар нь тус бүрдээ найман зуу гаруй үгтэй бөгөөд өөр хоорондоо харьцангуй төстэй юм.

Ибн-Муханны толийн талаар хамгийн анх П.М.Мелиоранский судалсан бөгөөд түүний олсон эх нь бүгд 25 хэсэг бүхий зүйл хуваасан толь байсан бөгөөд тэрбээр уг толийн 850 орчим үгсийг үсгийн дараалалд оруулан, араб бичлэг, орос орчуулга, дуудлагын галиг хийгээд тухайн үгсийн монгол бичлэгийн хамт сийрүүлэн буулгасан нь судалгааны аргын хувьд нэн тохиромжтой болжээ. Мөн энд уг дурсгалын авиа зүй, хэл зүйн үндсэн онцлог шинжүүдийг тодорхой жишээгээр тайлбарлаж, араб эх бичгийг хавсаргасан байна.⁴ Хожим профессор Н.Поппе 1921 онд Муаллима Рифата гэдэг хүн Истанбул хотноо хэвлүүлсэн өөр нэг хувилбарыг олж, 870 орчим үгийг латин галиг, араб бичлэг, орос орчуулгын хамт “Мукаддимат ал-Адаб” толийн судалгаандаа хавсралт болгон хэвлүүлсэн билээ.⁵ Өнгөрсөн зууны далаад оны эхээр Бонн их сургуулийн профессор М.Вайерс Ром

² Yoshio Saito, A Phonetic Study of the Middle Mongolian Language in Arabic Transcriptions, Tokyo Gakugei University, Tokyo, January 1997, 397 pp.

³ Г.Цэцэгдэрь – “Ибн-Муханны толийн хувилбарууд” -Bulletin of the International Association for Mongol Studies, No.1-2 (25-26), 2000, 75-80; No.1-2 (27-28), 2001, 58-61; No.1-2 (29), 2002, 97-118

⁴ П.М.Мелиоранский – “Араб филолог о монгольском языке”, Спб., 1903, стр.171

⁵ Н.Поппе – “Монгольский словарь Мукаддимат ал-Адаб”, /ТИВ 14/, т. I-II, М.-Л., 1938, 432-451

хотын Корзины номын санд хадгалагдаж байгаа араб монгол толийн нэгэн гар бичмэлийг олж судлаад түүнийг “Ибн-Муханны толь”-ийн бас нэгэн өөр хувилбар мөн болохыг тогтоожээ. Тэрбээр судалгаандаа уг толиос 230 гаруй үгсийг түүвэрлэн авч, латин үсгийн дараалалд оруулаад, уг тус бүрийг үсгийн галигаар буулгаж, герман орчуулга хадсанаас гадна “Монголын Нууц Товчоо”, “Ибн-Муханны толь”-ийн Истанбулын хувилбарын доторх тохирох үгстэй харьцуулан үзжээ. Мөн тэрбээр уг судалгаандаа тухайн дурсгалын гэрэл зургийн бүрэн эхийг хавсаргасан нь цаашид нарийвчлан судлахад чухал хэрэглэгдэхүүн болж байна.⁶

Энэхүү тольд бурханы нэр, тэнгэр ба тэнгэр бус, цаг улирал, газар, тэнгис, хүний биеийн эрхтэн, орон байр, идээ, ундаа, мод, жимс, үр тариа, багаж хэрэгсэл, зэр зэвсэг, хувцас, чимэглэл гэх мэт дорно дахины уламжлалт ангиллыг баримталснаас гадна үйл үг, сул үг гэх мэт үгсийн аймгийн зарим нэр орсон байна.

Лейдений гар бичмэл толь.

Голланд улсын Лейден их сургуулийн номын санд хадгалагдаж байгаа “*Kitab Majmu' Turjuman Turki wa-'ajami wa-Mugali*” буюу “Турк перс монгол хэлний толь” хэмээх энэхүү толь нь бүгд 76 хуудастай бөгөөд эхний 62 хуудас нь турк араб толь, 63b-67b дугаар хуудас нь 240 үгтэй монгол перс толь, 67b-74b дугаар хуудас нь 400 орчим үгтэй араб монгол толиос бүрджээ.

Хүний бие эрхтэн, төрөл садан, хоол унд, хувцас хунар, зэрлэг амьтан, агнуурын багаж зэвсэг зэрэг ангилал бүхий уг толийн зохиогч нь эдүгээ тодорхой мэдэгдэхгүй байгаа боловч түүнийг 1243 оны үед зохиогдсон гэж эрдэмтэд үзэж байна.

Монгол хэлний түүхэн судлалд нэн чухал энэхүү дурсгалыг профессор Н.Поппе судлахдаа уг толийн араб бичлэгт латин галиг, герман орчуулга дагалдуулж, улмаар зарим үгийг Гирогосын толь⁷, Мелиоранскийн хэвлүүлсэн “Ибн-Муханны толь”, Эвлия Челебийн тэмдэглэлд орсон монгол үгс болон монгол бичгийн бичлэгтэй харьцуулан авч үзжээ. Мөн тэрбээр уг дурсгалын авиа зүй, үг зүйн онцлог шинжийг дундад үеийн монгол хэлэнд холбогдох бусад бичгийн дурсгалуудын зохих материалтай харьцуулан судалсан нь түүхэн харьцуулсан судалгааны хувьд үнэтэй чухал бүтээл болжээ.⁸ Саяхан японы эрдэмтэн Ё.Сайто тус толийн гэрэл зургийн өнгөт эхийг үсгийн галиг, англи орчуулгын хамтаар хэвлүүлсэн байна.⁹

⁶ M. Weiers, Ein arabisch-mongolischer Wörterspiegel aus der Bibliotheca Corsini in Rom, ZS. 6, 1972, 7-29 + 30 Tafeln

⁷ Louis Ligeti, Le Lexique Mongol de Kirakos de Gandzak, AOH. 18, 1965, 241-297

⁸ N. Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift. – Bull. de l'acad. Des Sc. de l' URSS, 1927 (1009-1040, 1251-1274), 1928 (55-80)

⁹ Yoshio Saito, The Mongolian Words in Kitab Majmu' Turjuman Turki wa-'ajami wa-Mugali: Text and Index, Shoukadoh Kyoto, June 2005, xiii + 49 + 01a-75b

Истанбулын монгол толь.

Барагцаалбал XV зууны эцэс, XVI зууны эхээр Имад ал-Карахисари (*Hasan bin Husan 'Imad al-Qarahisari*) хэмээгчийн зохиосон “Шамил үл-луга” хэмээх турк перс гар бичмэл толь Истанбул хотын номын санд хадгалагдаж байгаа бөгөөд түүний ард дагалдуулал болон орсон араб перс турк монгол дөрвөн хэлний бэсрэгхэн толь нь монгол хэлний судлалд нэн чухал материал болж байна. Тэрхүү толийг хэн зохиосон нь тодорхойгүй байгаа бөгөөд XV зууны сүүчээс эхлэн Бага Азид Монголын нөлөө ихээхэн өсч ирсэн тэр үед хэн нэгэн хүн урьд өмнө гарсан толь бичгүүдэд тулгуурлан түүнийг эмхтгэсэн байх гэж академич Л.Лигети дурдсан байна. Истанбулын номын санд байгаа тэрхүү толь бүгд 167 хуудастай бөгөөд эхний 140 хуудас нь “Шамил үл-луга” хэмээх толь, 140-162 хүртэлх хуудас нь дээр дурдсан дөрвөн хэлний толиос бүрддэг байна. Энэхүү толийн дөрвөн эгнээ болгон жагсаасан хэлний дараалал хийгээд тоо, цаг улирал, газар тэнгэр, ургамал, амьтан, хүн, гэр орон, хоол унд, хувцас хунар гэх мэтээр зүйл хуваасан байдал нь угтаа Бухараас олдсон “Мукаддимат ал-Адаб толь”-той ихээхэн төстэй байгаа зэрэгт үндэслэн түүнийг эмхтгэгч нь “Мукаддимат ал-Адаб толь”-ийг ихээхэн ашигласан бололтой гэж зарим эрдэмтэн үзсэн байна.

Истанбулын толинд орсон 400 орчим монгол үгсийг Унгарын монголч эрдэмтэн академич Л.Лигети латинаар галиглаж, араб бичлэг, франц орчуулга дагалдуулснаас гадна үг тус бүрийг “Мукаддимат ал-Адаб”, “Ибн-Муханны толь”, “Лейдений толь”, “Монголын Нууц Товчоо”, “Хуа-й й-юү” гэх зэрэг араб, хятад үсгээр тэмдэглэсэн монгол хэлний бусад дурсгалууд болон монгол хэлний эртний шинжийг зохих хэмжээгээр хадгалан үлдсэн хэл аялгууны материалтай харьцуулан авч үзсэн байна.¹⁰ Мөн тэрбээр тухайн дурсгалын гэрэл зургийн эхийг хавсаргаж, түүний үсэг зүй, авиа зүйн гол шинжийг дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалуудтай харьцуулсан дэлгэрэнгүй судалгааг тусгайлан гаргасан билээ.¹¹

“Хамдуллаха Казвины толь”-д орсон монгол үгс.

XIV зууны Персийн түүхч Хамдуллаха Казвин (*Hamdu'llah al-Musta'fi al-Kazwini*)-ы 1339 оны үед зохиосон “Зүрхний гэрэл” хэмээх бүтээлд перс, турк, монгол гурван хэлээр бичсэн ан амьтны нэрс байгаагийн дотор дөчөөд монгол нэр байгаа нь үгсийн сан төдийгүй авиа зүй, үгийн бүтцийн нэн сонирхолтой материал болж байна. Тэдгээр үгсийн талаар Н.Поппе¹²,

¹⁰ L.Ligeti, Un vocabulaire mongol d'Istanbul, АОН 14, 1962, 3-99

¹¹ L.Ligeti, Notes sur le vocabulaire mongol d'Istanbul, АОН 16, 1963, 107-174

¹² Н.Поппе — “Монгольские названия животных в труде Хамдуллаха Казвини” ЗКВ т. I, 1925, 195-208

П.Пеллио¹³ нар судалжээ. Профессор Н.Поппе өөрийн судалгаандаа дөч гаруй үгийг монгол хэл аялгууны зохих үгстэй харьцуулснаас гадна тухайн үгэнд гарсан зарим авианы хувьслыг түүхэн үүднээс тайлбарласан бол П.Пеллио наяд гаруй үгийг араб үгсээр тэмдэглэсэн бусад бичгийн дурсгалын материалтай харьцуулан судалсан байна.

“Эвлия Челебийн толь”-д орсон монгол үгс.

Османы зохиолч Эвлия Челеби гэгч 1667 оны үед Умард Кавказ дахь Дагестаны Кайтакчуудын үг хэллэгийг тэмдэглэсэн хураангуй толинд их төлөв ан амьтны голлосон дөч орчим монгол гаралтай үг байсныг П.Пеллио судлан тусгай өгүүлэл нийтлүүлжээ. Тэрбээр уул судалгаандаа араб үгсээр тэмдэглэсэн монгол дурсгалуудын талаар товч дурдаад улмаар “Эвлия Челебийн толь”-д орсон монгол үгсийг араб бичлэг, латин галиг, турк үг, франц орчуулгын хамт жагсааж, үг тус бүрт холбогдох дэлгэрэнгүй тайлбарыг хийжээ.¹⁴

Зирнийн гар бичмэл.

1950-иад оны дундуур Японы нэрт монголч эрдэмтэн Ш.Ивамурагийн удирдсан хээрийн судалгааны анги Афганистанд ажиллах үедээ могол хэл аялгууны баялаг материал тэмдэглэн авч, бас зарим гар бичмэл ном олсны дотор бидний энд дурдаж буй гар бичмэл эхийг Зирни хэмээх газраас олжээ. Зирнийн толь нь бүгд 40 нүүр гар бичмэл бөгөөд тэр нь араб үгсээр бичсэн эртний эх бичгээс нэлээд хожуу дахин хуулсан хуулбар ажээ. Уг дурсгалын хэлний онцлог шинж болон үгийн сангийн байдлаас ажиглавал, тэр нь харьцангуй эрт үеийн дурсгал болох нь илт мэдэгдэж байна. Харин профессор Н.Поппе уг гар бичмэлийг хэдийгээр эртний шинжтэй боловч дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгал бус, зөвхөн могол хэлний дурсгал гэж үзсэнийг дурдъя.

Профессор Ш.Ивамура уул дурсгалыг зөвхөн олсон төдийгүй Нацуки Осада, Тадаши Ямазаки зэрэг эрдэмтэдтэй хамтран судалжээ.¹⁵ Тэд энэхүү судалгаандаа уул дурсгалын нарийвчилсан галиг, харьцуулсан толь, хэлний онцлогийн тухай товч тэмдэглэл хийсний дээр гэрэл зургийн эхийг хавсаргасан байна. Энд Зирнийн толийн дотроос нийт 360 гаруй монгол үгийг түүвэрлэн авч, араб, хятад үгсээр тэмдэглэсэн дундад үеийн монгол хэлний дурсгалууд болон орчин үеийн монгол

¹³ P. Pelliot, Les Formes turques et mongoles dans la nomenclature zoologique du Nuzhatu-'l-kulub, BSOS 6:3, 1931, 555-580

¹⁴ Paul Pelliot, Le Pretendu Vocabulaire Mongol des Kaitak du-Daghestan, JA. 12:9 (1927), 279-294

¹⁵ Shinobu Iwamura, The Zirni Manuscript. A Persian-Mongolian Glossary and Grammar, 1961, Kyoto Japan, IX + 161 + 42 plates

хэл аялгууны материалуудтай харьцуулан үзсэн нь уул судалгааны хамгийн сонирхолтой хэсэг нь юм. Мөн профессор Н.Поппе энэхүү дурсгалын хэлний онцлог шинжийн талаар хийсэн тусгай тэмдэглэлдээ нэг талаас, монгол хэлний хөгжлийн харьцангуй эртний шинж, нөгөө талаас дундад үеийн монгол хэлнээс хойших үеийн шинж, тухайлбал, могол хэлний шинж туссан тухай дурджээ.

Дундад үеийн монгол хэлийг тэмдэглэсэн араб үсгийн дурсгалуудын талаар гарсан эдгээр судалгаанууд нь юуны өмнө тэдгээрийг судалгааны ертөнцөд танилцуулсан төдийгүй, тэдгээрийг галигчлан буулгаж, улмаар дурсгал тус бүрийн хэлний онцлог шинжийг янз бүрийн түвшинд авч үзсэн байна.

Эдгээр дурсгалууд нь галигласан зарчимынхаа талаар өөр хоорондоо нэгдэлгүй болсны дээр ихэнх дурсгалыг үсгийн галигаар буулгалгүй, шууд дуудлагын галигаар буулгасан тул уншиж тэмдэглэсэн үгс нь зарим талаар тааврын шинжтэй болсноор судалгааны найдвартай эх материал болж чадахгүйд хүрчээ. Иймээс тэдгээр дурсгалуудыг судалгааны нэгдэлтэй арга зүйгээр судалж, дурсгал тус бүрийг үсгийн галигаар буулгах, улмаар араб үсгийн бичлэг, дундад үеийн монгол хэлний авианы тогтолцоо хоёрыг тэгш харгалзсан зарчмаар дуудлагыг буулгах нь чухал болж байна. Ингэснээрээ нэг талаас араб үсгийн монгол дурсгалуудын авианы бүтэц, тогтолцоо, үгийн бүтэц, хэлбэр, үгийн сангийн бүрэлдэхүүнийг улам нарийвчлан тогтоох, нөгөө талаас тэдгээр дурсгалуудыг хятад, дөрвөлжин үсгээр тэмдэглэсэн бусад дурсгалуудтай харьцуулан дундад үеийн монгол хэлний үндсэн онцлог шинжүүдийг илүү тодорхой тогтоох боломжийг академич Д. Төмөртогоо эрэлхийж, нэг сэдэвт зохиолыг хэвлүүлсэн байна.¹⁶

Расулидын зургаан хэлний толь.

Йемен улсын Аден хотноо нэгэн хувь хүний эзэмшилд буй үнэт ховор гар бичмэл номын цуглуулгын дотор араб, перс, турк, грек, армен, монгол зэрэг зургаан хэлний үгийг багтаасан үлэмж сонирхолтой толь хадгалагдаж байна. Түүхэнд “Хааны толь” хэмээн алдаршсан энэхүү толийг Расулидын ван Ал-Аббас Али (*al-Malik al-Afdal al-'Abbas b. 'Ali*) гэгч зохиожээ. Тэрбээр “*Fusul Majmu'a fi'il-Anwa wa'l-zuru'wa 'l-Hisad*” хэмээх шастир, тэмдэглэл бүхий түүврийн зохиогч бөгөөд түүний түүвэрт одон орон судлал, зурхай судлал, хуанлийн систем, газар тариалан, мал аж ахуй, дайн, цэргийн технологи, нэр томъёо судлал, шүүхийн тэмдэглэл, эрүүл мэнд, анагаах болон эм зүйн ухаан, хоол хүнс, газар зүй, гарал судлал, эдийн засгийн ухаан, улс төрийн онолын холбогдолтой

¹⁶ Д.Төмөртогоо - “Араб үсгийн монгол дурсгалын судалгаа: Удиртгал, үсгийн харьцуулсан толь, ном зүй, *Monuments in Mongolian Language*, Vol. III, Уб., 2002, V + 177

материалууд болон “Расулидын зургаан хэлний толь”, мөн араб этиоп хэлний товч толь зэрэг багтсан байдаг.

Тэнгэр, газар, хүний бие эрхтэн, садан төрөл, цаг улирал, газарзүй, байгалийн үзэгдэл, гэр орон, сав суулга, мод жимс, ургамал ногоо, үр тариа, хоол унд, хувцас хунар, бөс бараа, үнэт чулуу, ан амьтан, араатан жигүүртэн, хорхой шавж, өнгө зүс, зэр зэвсэг, өвчин эмгэг, тоо хэмжээ, ажил мэргэжлийн холбогдолтой үгсийг багтаасан уг толинд дундад зууны үед Газрын дундад тэнгисийн эргэн тойрны орнуудын улс төр, соёлын гол хэл байсан араб, перс, турк, грек зэрэг хэлний хамт монгол хэлний үгсийг багтаасан нь Монголын эзэнт гүрний нөлөө тэр үеийн Ойрх дорнодод хэр зэрэг байсныг харуулах түүхэн гэрч болж байна.

Америкийн түүхч эрдэмтэн П.Б.Голден арван дөрөвдүгээр зууны үеийн зургаан хэлний Расулидын толийн тухай томоохон бүтээлийг эрхлэн гаргажээ.¹⁷

“Расулидын зургаан хэлний толь”-ийн олон улсын төсөл нь 1960-аад оны сүүлээр хэрэгжиж эхэлжээ. Тухайн үеийн Колумб их сургуулийн Түрэг судлалын профессор Тибор Халаш Күн (*Tibor Halasi-Kun*) Сирийн араб аялгуун дахь оттоман түрэг хэлний үгсийн талаарх материалыг Бейрутад байх үеэсээ цуглуулж байжээ. Түүнийг Бейрутад байх үед нь Леванийн эрдэмтэн Махмуд ал-Гүл (*Mahmud al-Gul*) гэгч Йименээс олдсон араб үсгээр бичсэн олон хэлний маш ховор толийн гар бичмэлийн иж бүрэн гэрэл зургийг түүнд өгөөд, хэвлүүлэхийг хүссэн байна. Профессор Халаш Күн 1974 онд тус зургаан хэлний толь дээр хамтран ажиллах олон улсын эрдэмтдийн багийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Үүнд, Халаш Күн түрэг хэлний материалыг, Рутгерс их сургуулийн Төв Ази, дундад Дорнодын түүхийн судлалын профессор П.Б.Голден (*P.B. Golden*) грек хэлний материалыг, Унгарын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, Будапешт их сургуулийн Дорнод Азийн судлалын тэнхимийн эрхлэгчээр олон жил ажилласан Л.Лигети монгол хэлний материалыг, Унгарын шинжлэх ухааны академийн судлаач Эдмүнд Шүц (*Edmur d Schutz*) армен үсгээр тэмдэглэсэн үгсийг тус тус хуваан авчээ. Мөн Ү.алаш Күн, Голден нар араб, перс хэлний материал дээр хамтран ажиллажээ.

Зургаан хэлний толийн судалгааны багийн анхны зорилго нь уул толийн бүрэн галигийг түрэг, монгол, грек, армен толиудын тухай судалгааны ганц сэдэвт зохиолын хамт хэвлүүлэхэд оршиж байв. Гэвч тэдгээрээс грек хэлний материалын талаарх Голденy ганц сэдэвт зохиол д хэвлэгдсэн байна.¹⁸

¹⁷ P.B.Golden, *The King's Dictionary. The Rasulid Hexaglot*, Brill, Leiden-Boston-Koln, 2000, xiii + 418 + Ms.p. 186-211

¹⁸ P.B.Golden, *The Byzantine Greek Elements in the Rasulid Hexaglot. Archivum Eurasiae Medii Aevi*, V (1985 [1987]), 41-166

1978 онд Америкийн хүн судлаач, эдүгээ Расулид судлалын гол эрдэмтдийн нэг Хофстра (*Hofstra*) их сургуулийн профессор Даниел Вариско (*Daniel Varisco*) тухайн үед Америк-Унгарын судалгааны багт мэдэгдээгүй байсан нэгэн гар бичмэлийн гэрэл зургийг дарсан нь дундад зууны Йемений түүх, соёлын салбар дахь Английн ахлах мэргэжилтэн профессор Р.Б.Сержийнт (*R. B. Serjeant*)-ийн анхааралд өртсөн байна. Тэд уг гар бичмэлийн хуулбарыг хэвлүүлэх санаатай байв. Энэ нь 1998 онд профессор Г.Рекс Смит (*G. Rex Smith*) болон Вариско нарын нэрээр хэвлэгджээ.¹⁹

1992 онд профессор Вариско, Голден нар уулзаж, Расулид гар бичмэлийн эхийг шүүн хэлэлцсэн бөгөөд тэд Йемен Судлалын Америкийн Институтын тусламжтайгаар төслийг амжилттай үргэлжлүүлэн дуусгажээ.

“Расулидын зургаан хэлний толь” нь хэд хэдэн толиос бүрддэг. Эхний хэсэг буюу гар бичмэлийн 186-197 дугаар тал нь араб перс түрэг грек армен таван хэлний толиос бүрдэх бөгөөд хоёр баганаар бичигджээ. Дараагийн хэсэг буюу гар бичмэлийн 197-205 дугаар тал нь араб перс түрэг монгол дөрвөн хэлний толиос бүтнэ. Тус гар бичмэлийн хоёр хэсгийн аль алинд байгаа тэгш тоотой хуудсан дахь гурван багана бичлэгийг баруунаас зүүн тийш уншина. Харин сондгой тоотой хуудсан дахь эхийг зүүнээс баруун тийш уншина. Ихэнх хуудас нь 29, 30 мөртэй.

XIV-XV зууны монгол хэлний үгсийг тэмдэглэсэн эдгээр толь бичгүүд нь дундад үеийн монгол хэлний авианы бүтэц тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийг нарийн тодорхой тусгаснаараа зөвхөн үгийн сангийн үнэтэй чухал дурсгал төдийгүй, монгол хэлний түүхийн үнэтэй чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Бид энд араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсгалуудын зарим онцлог шинжийн талаар товч дурдъя.

Урт эгшиг. Утга ялгах өргөлтөт эгшгээс үүссэн үүсмэл урт эгшгүүдийг тэмдэглэсэн байдал нь хятад, дөрвөлжин үсгийн дурсгалуудтай адил юм. Харин эгшиг авианы ижилшлийн улмаас сулран сугарсан гийгүүлэгчийн хувьслыг илүү нарийн тэмдэглэсэн зүйл ажиглагдаж байна.

u: < u'u: < o'u: < a'u: < awu: < ayu:

“уул” *u:la* (Mu.276b) < **u'u:la* < **o'u:la* < *a'u:la* (Mu.189a) < **awu:la* < *ayu:la*

¹⁹ D.M.Varisco, G. R. Smith, the Manuscript of al-Malik al-afdal al'-Abbas b.'Ali Da'ud b. Yusuf. B. 'Umar b. 'Ali Ibn Rasul. A Medieval Arabic Anthology from the Yemen (gibb Memorial trust Fund, Warminster, 1998)

(Sul.31)

u: < u'u: < uwu: < awu: < ayu:

“муу” *mu:* (Mu.157b) < **tu'u:* < *tuwu* (Mu.321a) < *tawu:*
(Ibn.I.13:2) < *mayu:*

(Sub.192)

u: < u'u: < i'u: < iyu: < iyu:

“харуу” *qaru:* (Mu.254b) < **qaru'u:* < *qari'u:* (Mu.294a) <
qariyu: (Mu.294b) < *qariyu:* (Mu.294a)

u: < u'u: < uwu: < iwu: < iyu:

“ариун” *aru:n* (Zir.11:3a) < **aru'u:n* < *aruwu:n* (Ist.17) < **ariwu:n*
< *ariyu:n*

(Sub.63)

u: < u'u: < uwu: < uyu:

“хуруу” *quru:n* (Mu.147b) < *quru'u:n* (Mu.124a) < *quruwu:n*
(Ist.47) < *quruyu:n*

(Sub.359)

Мөн тэдгээр дурсгалуудад хоёр эгшгийн дундаас сулран сугарсан гийгүүлэгчийн байранд үлдсэн амьсгалын түрэлт нь бүрмөсөн гээгдэж, арын урт эгшиг нь өмнөх үеийнхээ богино эгшигтэй нийлж нэгэн үе болсон нь дундад үеийн монгол хэлний бусад дурсгалуудад өгт тохиолддоггүй сонирхолтой бичлэг юм.

“цагаан” *čaqa:n* (Mu. 129a, Zir. 13:7) < *čaqa'a:n* (L.1272)

“боол” *bo:l* (Mu. 109a) < *bo'o:l* (L. 1266) < *bo'a:l* (Mu. 189a)

“ариун” *aru:n* (Zir. 11:3a) < *ari'u:n* (Mu. 105b) < *ariyu:n* (Mu. 106a)

“элээ” *hele:* (L. 76) < *hele'e:* (L. 76) < *heli'e:* (E. 289)

“тэргүүн” *terü:n* (L. 1269) < *terü'ü:n* (L. 1269) < *teriyü:n* (Ibn.I. 16:8)

Хос эгшиг. Үгийн эцсийн бус хос эгшиг нь дөнгөж дундад үеийн монгол хэлний үед үүсэн бүрэлдэж байсан учир зарим тохиолдолд шинээр үүсэн бүрэлдсэн хос эгшигийг тусгаж, зарим тохиолдолд хос эгшиг үүсээгүй байсан байдлаар тэмдэглэсэн байна.

“сайн”
“хойно”

sain (Mu. 158b, Is. 63) *sayī:n* (Mu. 96a, L. 1252)
goīna (Mu. 103b) *qoyī:na* (Mu. 306a)

Эгшигийн ижилшил.

а. Тэргүүн бус үеийн уруулын бус богино эгшиг нь тэргүүн үеийн уруулын богино эгшигтээ татагдан дэвшин ижилшсэнийг тусгажээ.

“олон”
“босго-”
“бөхөн”
“өргөн”

olon (Mu.230b) < *olan* (Mu.264a)
bosqo- (Zir.6:5a) < *bosqa-* (Mu.122)
bökön (Mu.345b) < *böken* (Zir.20:5)
örgön (Ibn.II 443b) < *örgen* (Ibn.I 14:4)

б. Тэргүүн үедээ уруулын эгшигтэй үгийн тэргүүн бус үеийн уруулын бус урт эгшиг нь тэргүүн үеийн өргөлтөт, уруулын богино эгшигт татагдаж дэвшин ижилшсэнийг тусгасан байна.

“долоо”
“зөөлөн”

dolo:n (Zir.25:2a) < *dola:n* (Mu.142b)
jö'ö:len (Mu.209a) < *jö'e:len* (Mu.133a)

в. Тэргүүн үеийн уруулын бус богино эгшиг нь тэргүүн бус үеийн уруулын богино эгшигтээ татагдан ухран ижилшжээ.

“цус”
“хутга”
“илд”
“нүд”
“өмс-”
“өмнө”

čusun (Zir.3:7b) < *čisun* (Mu.97a)
qutuya (Mu.209b) < *qituya* (Mu.299a)
hüldü (Ist.35) < *hildü* (Mu.129b)
nüdü:n (Zir.2:3a) < *nidün* (Mu.97a)
ömüs- (Mu.116a) < *emüs-* (Mu.286a)
ömüne (Mu.110b) < *emüne* (Mu.155a)

г. Тэргүүн үеийн уруулын бус богино эгшиг нь тэргүүн бус үеийнхээ уруулын, урт эгшигт татагдан ухран ижилшжээ.

“дуул-”
“дүү”

du'u:la- (Mu.147a) < *da'u:la-* (Mu.139a)
dü'ü: (L.1256) < *de'ü:* (Mu.151b)

Үгийн бүтэц. Дээрх толь бичгүүдийн үүсмэл үгсийн бүтцийг ажиглавал, нэр ба үйл үгсийн бүтэх байдал нь бусад дурсгалуудтай нийтлэг шинжтэй боловч зарим нэгэн өвөрмөц дагавар байгааг онцлон дурдъя.

-*yalan/-gelen*

“*шар + галан*” sira + yalan = sirayalan (Zir.13:9a)

-*ji*

“*ур + ж(угдар)*” uri + ji = uriji (Mu.366b)

-*lar/-ler*

“*адуу + нууд*” adu:sun + lar = adu:sunlar (Mu.290b)

“*эм + с*” eme + ler = emeler (Mu.263b)

-*liy/-lig*

“*анд + лиг*” anda + liy = andaliy (Mu.103a)

“*өвчин + лиг*” ebečin + lig = ebečinlig (Mu.333b)

Хэл зүйн хэлбэр. Араб үгсийн монгол дурсгалуудад хэлзүйн хэлбэрүүдийн олон хувилбар бичлэг тохиолддог нь авианы хувьслын олон үе шатыг нарийн тусгасантай холбоотой юм. Тухайлбал, нэр үгийн тийн ялгалын нөхцөлийн дараах хэлбэрүүд тэмдэглэгджээ.

-un/-ün, -u/-ü, -yin, -nu/-nü, -i, -i:n,

-du/-dū, -tu/-tū, -dur/-dür, -tur/-tūr,

-da/-de, -ta/-te, -a/-e, -na/-ne,

-ča/-če, -a:ča/-e:če, -a:sa/-e:se, -wa:sa/-we:se, -ya:sa/-ye:se,

-i'a:r/-i'e:r, -wa:r/-we:r, -ya:r/-ye:r, -a:r/-e:r,

-la/-le:

-tai/-tei

Араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний толь бичгүүдэд нийтлэг тохиолдож байгаа үгсийг зүйл хуваасан ангилалтай нь уялдуулан, үгсийн сангийн бүрэлдэхүүнийг нь баримжаалан тодорхойлвол,

Нэр үг

Хүний эшийн нэрс: *авга, ах, бэр, бэргэн, хүргэн, бөл, дүү, эцэг, эх, эгч, эр, эм, эмгэн, хүүхэн, хөвгүүн, нагац, өвгөн, охин, хадам, хатагтай*

Бие эрхтний нэрс: *бие, тэргүүн, эх(толгой), орой, гээг, нүүр, царай, чих, нүд, хөмсөг, сормуус, аньсага, ам, хамар, хэл, уруул, сахал, эрүү, хацар, араа, шүд, хүзүү, хоолой, эгэм, мөр, цээж, нуруу, ууц, сүүж, хавирга, өвчүү, хөх, элэг, зүрх, уушги, бөөр, гүзээ, гэдэс, бөгс, баагуур, сүүрэл, озгой, бөлдөг, хярган, умай, үтэг, хэлүү, өндөг // гар, тохой, нударга, бугуй, алга, хуруу, чигчий //хөл, гуя, шилбэ, тахим, өвдөг, шагай, борви, өлмий, өсгий, //арьс, мах, цус, судас, шөрмөс, үс, хуйх, яс, өөх*

Ажил мэргэжлийн нэрс: адууч(ин), агтч(ин), хоньчин, нохойчин, тэмээчин // авч(ин), барсчин, загасчин // алтач(ин), амбаарч(ин), аягач(ин), багчин (цэцэрлэгч), балгасчин, бөсчин, газарчин, дээлчин, дээсчин, онгоцчин, салчин, тариачин, тосчин, усчин, төмөрчин, үүдчин (хаалгач), хөөрөгчин, цаасчин, шивээгчин, эсгийчин // бичээч, борч (дарсчи), гуйранч, оточ, хорч, элч, эмч // боол, дарга, душман, занги, ноён, зайран, ортуут (худалдаачин) цагдуул, цэрэг, хэвтүүл, эрхүүд, шавь

Гэрийн гэжээмэл амьтны нэрс: мал, азарга, гүү, унага, даага, бух, үхэр, үнээ, бяруу, тугал, гуна, ямаа, ухна, тэмээ, ингэ, ботго, морь, хонь, хуц, хурга, төлөг, луус, илжиг, гахай

Ан амьтны нэрс: луу, заан, арслан, барс, шилүүс, үнэг, чоно, тэх, хулан, марал, бөхөн, зээр, гөрөөс, бичин, буга, булга, хүдэр, бүжин, дорго, мануул, мигуй, суусар, загас, зараа, зулзага, хэрэм, бах, мэлхий, могой, нохой, өтөг, хавлан, халиу, хулгана, туулай, хорхой, бөөс, бүүрэг, шумуул

Жигүүртний нэрс: шувуу, бүргэд, идэлэг, шонхор, элээ, салбар, тоодог, тогоруу, ангир, бөднө, ятуу, хөхөө, ууль, нугас, лачин, тахиа, / эрвээхий, соно

Ургамал ногооны нэрс: ари, бургас, цэцэг, өвс, мод, бут, навч, хулс, сухай, яргай, гүйлс, гүл, алим, арвай, буудай, буурцаг, тариа, тутарга, жимс, сонгино, сармис

Багаж зэвсэг, тоног хэрэглэлийн нэрс: анжис, онгоц, тээрэм, зэвсэг, илд, жад, сэлэм, нум, сум, хутга, хөрөө, хүрз // буйл, бурантаг, цулбуур, дээс, эмээл, тохом, гөлөм, жирим, ногт, хазаар, зуузай, чөдөр, уурга, минаа, бэрээ, аргамж, оломцог, янгирцаг // сүх, хадаас, шөвөг, зүү, утас, хатгуур, билүү, дөш, ооль, хайч, сам, тэвш, тулам, тогоо, шанага, аяга, халбага, жалавч

Тэнгэр, газар усны нэрс: тэнгэр, нар, сар, од, үүл, манан, будан, хур, цас, хий // газар, шороо, уул, гүр (чулуу), булаг, нуур

Зүг чиг: баруун, зүүн, өмнө, хойно, урд

Хоол, унд: хүнс, бяслаг, этмэг (талх), идээ, будаа, бяслаг, хурууд, давс, хоног, гурил, шихэр, бал, шөл, сүү, тараг, дарс, ундаа

Цаг улирлын нэрс: он, өвөл, хавар, зун, намар, сар, өдөр, шөнө, үдэш, ноднин, маргааш, өчигдөр, уржидар

Хувцас хунар: дээл, тэрлэг, цамц, өмд, бүс, малгай, эрхийвч, хуруувч, хөнжил, оймс, өлгий, ханцуй, товч, бүч

Өнгө зүс: цагаан, улаан, хөх, ногоон, хар, шар, шарга, бор // буурал, хээр, цавьдар, цоохор

Оноосон нэр: Исүс, Араб, Ирак, Йемен, Индүс, Мусулман, Сартуул

Хийсвэр нэрс: сэтгэл, итгэл, баясгалан, зовлон, заяа, хүсэл, нүгэл, буян, хуял, зүүд, нойр, аюул, заль, өвчин

Ялгадасын нэр: баас, шээс, нулимс

Тэмдэг нэр

их, бага, бүдүүн, нарийн, хүнд, хөнгөн, урт, богино, илүү, дутуу, халуун, хүйтэн, зузаан, нимгэн, бэрх, сайн, муу, цэцэн, мунхаг, цатгалан, өлсгөлөн, шинэ, хуучин, эрүүл, өвчинт, гашуун, амттай, гэнэн, хашир, өчүүхэн, цөөн, хэдэр, хатуу, ширүүн, бөгтөр, доголон, сохор, хэлгий, дүлий, балай, бэлэвсэн

Тооны нэр.

nigen, qoyar, qurban, dörben, tabun, jürya:n, dolo:n, naiman, yisün, harban, qorin, yücün, döcün, tabin, jüran, dalan, nayan, tiren, ja'u:n, mingyan // tabuda:r, jüyuda:r, naimanda:r, yisüde:r // qoya'u:la // nigente:, qoyarta // nije:d

Үйл үг.

ав-, ай-, ал-, алх-, амс-, асуу-, бай-, бари-, баяс-, бэлэвсэр-, бичи-, бол-, бос-, бүж-, бөөлжи-, чад-, дэлэд-, долоо-, эр-, гар-, уя-, ид-, ир-, яар-, зас-, хэл-, хий-, хүр-, мэд-, наад-, нөгчи-, ор-, өг-, хатгалд-, харва-, худалд-, сэдхи-, сонос-, тави-, үз-, үх-, яв-, зорчи-

Төлөөний нэр.

Биеийн төлөөний нэр.

а. Ганц тоот нэгдүгээр биеийн төлөөний нэр *bi* нь *min-*, *nad-* ~ *nid-*, *nam-* гэсэн язгуурын хувилбаруудаар, олон тоот нэгдүгээр биеийн төлөөний нэр нь *ba* ба *bida* гэсэн хоёр хэлбэрээр байхаас гадна *bidad* гэсэн үүсмэл үндэс бүхий хэлбэр гагц Зирнийн тольд тохиолдож байна.

б. Ганц тоот хоёрдугаар биеийн төлөөний нэр *ci* нь *cin-*, *cita-* гэсэн язгууруудаар, олон тоот хоёрдугаар биеийн төлөөний нэр нь *tan-* гэсэн хэлбэрээр нэрийн тийн ялгалын нөхцөлийн өмнө тохиолдож байна.

в. Эртний монгол хэлний гуравдугаар биеийн төлөөний нэрийн олон тооны **a-* гэсэн үндэс нь бие даасан шинжээ алдаж, зөвхөн зарим тийн ялгалын үндсэнд тохиолдох болсныг харуулсан цөөвтөр жишээ зарим дурсгалд тохиолдож байна.

Заах төлөөний нэр.

- а. *e- язгуурт заах төлөөний үг нь нэрийн ганц ба олныг төлөөлөн заасан *epe, ede*, үйлийн байрыг төлөөлөн заасан *ende*, үйлийн шинжийг төлөөлөн заасан *eu:n* гэсэн хэлбэрүүдээр,
- б. *te- язгуурт заах төлөөний үг нь ганц ба олон тоот нэрийг төлөөлөн заасан *tere, tede*, үйлийн хир хэмжээг төлөөлөн заасан *tidь, tidьi*, үйлийн шинжийг төлөөлөн заасан *ti:m, ti:n*, үйлийн байрыг төлөөлөн заасан *tende* гэсэн хэлбэрүүдээр тохиолдож байна.

Ибн-Муханны толь

ضربت ضربنا ضربت ضربنا ضربنا ضربنا
 1. بي دلنيا بادلتنا بي دلنيا بادلتنا بادلتنا بادلتنا
 ضربوا ندادلتنا

وكذا في الأفعال المستقبله
 اضرب اضرب اضرب اضرب اضرب اضرب
 3. بي دلتمو بادلتمو بي دلتمو بادلتمو
 اضرب لاضرب لاضرب لاضرب لاضرب
 4. دلت بودلت اسادلت اسادلتمو

وكذا يقول

ضربني ضربيه ضربك ضربنا ضربهم
 6. بين دلنيا دلنا با جنو دلنيا ندادلتنا ندای دلنيا

وكذا في نيات الفعايل الاسميه

فربي فربنا فربك فربنا فربهم
 8. بين موري ماناي موري جني موري تاناي موري نداناي موري
 عندى عندنا عندكم عندهم عندك
 9. نادر ناند ناند ناند ناند ناند

وفي ضمائر الحرفيه